

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2022 он 09 сарын 02 өдөр

№ 96 / 2022

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Нэг талаас “Хэрлэн-Эрдэс-Хими” ХХК /цаашид “гүйцэтгэгч” гэх/-ийг төлөөлж Сургалтын менежер Батхуяг овогтой Шинэбаяр, нөгөө талаас “Амгалан дулааны станц” ТӨХК /цаашид “захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Шагдарсүрэн овогтой Баянмөнх нар Иргэний хуулийн 476-480 дугаар зүйл, Монгол Улсын Түлш, эрчим хүчний сайдын 2007 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 93 дугаар тушаалаар батлагдсан Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн 7.2.1, Уурын ба ус халаах зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн 9.2.2, Уурын ба халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн 6.1.8.1 дэх заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор дараах гэрээг харилцан тохиролцож байгуулав.

Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах, Уурын ба ус халаах зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах, Уурын ба халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн шаардлагын дагуу анхан, давтан сургалтыг зохион байгуулах, шалгалт авах, мэргэжлийн үнэмлэх олгох, эрхийн хугацааг сунгах ажлыг гүйцэтгэхэд гэрээний зорилго оршино.

Хоёр. Гэрээний үнэ, төлөх нөхцөл

2.1. Захиалагч нь Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах, Уурын ба ус халаах зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах, Уурын ба халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмүүдийн дагуу зохион байгуулагдах сургалтанд хамрагдах нэг ажилтны сургалтын төлбөрийг 75 000 төгрөгөөр тооцож нийт 63 ажилтны сургалтын төлбөрт нийт 4 725 000 (дөрвөн сая долоон зуун хорин таван мянга)-н төгрөгийг Гүйцэтгэгчийн ХААН банк дахь 5422096741 дансанд шилжүүлнэ.

Гурав. Хугацаа

3.1. Сургалтыг “Амгалан Дулааны Станц” ТӨХК-ийн Хурлын танхимд 2022 оны 09 дүгээр сарын 02, 12-ны өдрүүдэд зохион байгуулна.

3.2. Энэхүү гэрээ нь хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Дөрөв. Талуудын хүлээх үүрэг.

Захиалагчийн хүлээх эрх үүрэг:

- 4.1. Ажилтнуудыг сургалтанд идэвхтэй суралцах, хичээлээс хоцрох, таслах явдлыг гаргахгүй байх.
- 4.2. Гүйцэтгэгчийн шаардсанаар захиалагч холбоотой мэдээ, мэдээллээр хангана.
- 4.3. Гэрээнд заасан хугацаанд сургалт явуулахыг гүйцэтгэгчээс шаардана.
- 4.4. Сургалт явуулах байраар хангана.
- 4.5. Сургалтын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд шилжүүлнэ.

Гүйцэтгэгчийн хүлээх эрх үүрэг:

- 4.1. Сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу чанартай зохион байгуулна.

- 4.2. Гүйцэтгэгч нь гэрээний Хавсралт №2-г заагдсан ажилтнуудыг анхан ба давтан сургалтанд хамруулж, сургалтын төгсгөлд шалгалт авна.
- 4.3. Шалгалтанд тэнцсэн ажилтнуудад мэргэжлийн үнэмлэх олгох, ба хүчинтэй хугацааг сунгах асуудлыг 7 хоногийн хугацаанд шийдвэрлэнэ.
- 4.4. Гэрээний төлбөрийг хугацаандаа олгохыг шаардах.
- 4.5. Сургалтын гарын авлагыг цахимаар хангана.

Тав. Бусад

- 5.1. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд талууд нэмэлт гэрээг үндсэн гэрээнд хавсаргах ба нэмэлт гэрээ нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байна.
- 5.2. Гэрээнд тусгаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.



ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ш.БАЯНМӨНХ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛСИЙН
ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН
БОДОГЧ

 Ө.УДВАЛ


ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

 Б.ГАН-ОЧИР

СУРГАЛТ, СУДАЛГААНЫ
МЭРГЭЖИЛТЭН

 Н.ПАГМАА

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
“ХЭРЛЭН ЭРДЭС ХИМИ” ХХК-ИЙН
СУРГАЛТ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ
Ц.СҮНЖИДМАА

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР

Б.ШИНЭБАЯР



ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ, БАЙРШИЛ:

Захиалагч:
Амгалан дулааны станц ТӨХК
Хаяг: БЗД, 8-р хороо, УС-15-1-1
Утас: /976-11/ 77111249,
Факс: /976-11/ 77111253

Гүйцэтгэгч:
Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 7-р хороо, Эрхүүгийн
гудамж, 11-р хороолол, Одкон
Холдинг оффис 309 тоот
Утас: 976-99046379



Odson Holding suite 302
11 th Khovdooli, Erkhii avenue,
7 th khoroо, Sukhbaatar district
Улаанбаатар-14192, Mongolia
e-mail: batkhayvaa.smykbaataryan@gmail.com
tel: 976-99046379

СҮРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

№	Мэргэжлийн сургалтын нэр	Сургалтын сэдэв	Сургалтын агуулга	Сургалтын цаг			
				Давтан суралцагч Ажлын	Ажлын	Анхан суралцагч Ажлын	Ажлын
1	1. Зуухны бүрэн байдал, аюулгүй ажиллагааг харуулагч 2. Зуухны машинч 3. Тээрийн машинч	✓ Уурын ба ус халаах зуух төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм ✓ Даралгат савыг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм	<ul style="list-style-type: none"> ➢ Зуухны материал, түүнд тавигдах шаардлага ➢ Техникийн материал, үл эвдэх болон эвдэх сорил ➢ Зуухны тоноглолууд болон түүнд тавигдах шаардлага ➢ Гангуурын технологид тавигдах шаардлага ➢ Зуухны усны чанар, ус зөөлрүүлэх аргачлал ➢ Зуухны шат, тавцан, гэрэлтүүлэлт ➢ Техникийн бичиг баримт хөтлөлт, уялг хийх 	12 цаг	8 цаг	24 цаг	16 цаг
			<ul style="list-style-type: none"> ➢ Даралгат савны материал, түүнд тавигдах шаардлага ➢ Даралгат савны техникийн бичиг баримт хөтлөлт ➢ Баллоны ашиглалт ➢ Цистерны ашиглалт ➢ Уурын ба халуун усны шугам хоолойн материал, тавигдах шаардлага ➢ Тулгуур, бэхлэгсэ ➢ Хаалт, арматур ➢ Дулаан тэглэлт 				
2	1. Даралгат савны бүрэн байдал, аюулгүй ажиллагааг харуулагч 2. Даралгат сав, шугам хоолойтой харьцан ажигладаг ажигтан 3. Турбины машинч 4. Насосны машинч 5. Мазуурын машинч 6. Гангуурчид	✓ Даралгат савыг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм ✓ Уурын ба халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм	<ul style="list-style-type: none"> ➢ Даралгат савны материал, түүнд тавигдах шаардлага ➢ Техникийн материал, үл эвдэх болон эвдэх сорил ➢ Гангуурын технологид тавигдах шаардлага ➢ Турбины бүтэц, ашиглалт ➢ Даралгат савны техникийн бичиг баримт хөтлөлт ➢ Баллоны ашиглалт ➢ Цистерны ашиглалт ➢ Уурын ба халуун усны шугам хоолойн материал, тавигдах шаардлага ➢ Тулгуур, бэхлэгсэ ➢ Хаалт, арматур ➢ Дулаан тэглэлт 	12 цаг	8 цаг	24 цаг	16 цаг

“МОНГОЛЫН УР ЧАДВАР СУРГАЛТЫН ТӨВР”-ийн Сургалт харуулсан захирал

МХЕГ ДЭД БҮТЭЦ ИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР, Эрчим хүч, хэмжигдэрийн хяналтын хэлтсийн дарга



Ц.Сүмжидмаа
А.Бямбадорж